

Хоол үйлдвэрлэл үйлчилгээний эцэг, эхийн оролцоо, хяналт хариуцсан мэргэжилтэн, Дамдиндорж Номин-Эрдэнэ

2025 ОНЫ ХАГАС ЖИЛ-Н ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

НЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт	Эхэлсэн, дууссан хугаца	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
1.1. Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын хоол үйлдвэрлэл, үйлчилгээний талаарх төрийн бодлого, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг хэрэгжүүлэх							
1	Сургуулийн өмнөх боловсрол болон ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний чиглэлээр эцэг эх, асран хамгаалагчдад зориулан хууль, дүрэм, журамд нийцсэн зөвлөмж	Боловсруулсан зөвлөмжийн тоо Гүйцэтгэлийн хувь	0	1	Хүүхдийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээг сайжруулах шим тэжээлийн тэнцвэртэй байдлыг хангах хүрээнд сургуулийн өмнөх боловсрол болон ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний чиглэлээр эцэг эх, асран хамгаалагчдад зориулан 2 зөвлөмжийг боловсруулан Боловсролын ерөнхий газрын цахим хуудсанд байршуулсан. Үүнд: 1. “Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөр”-ийг тохиолдуулан эцэг эх, асран хамгаалагчдад зориулан баярын бэлэг сонгоход туслах зөвлөмж 2. Хүүхдийн эрүүл мэндийг хамгаалах хүрээнд баталгаагүй хүнсний бүтээгдэхүүн худалдан авахаас урьдчилан сэргийлэх зөвлөмж цуврал постер бэлтгэн Боловсролын ерөнхий газрын пейж хуудсан дээр нийтлүүлсэн. https://www.facebook.com/share/p/15Kk6hxd1T/?mibextid=oFDknk/90 удаа хуваалцсан байна./ https://www.facebook.com/share/p/1CWwmuspME/?mibextid=oFDknk/235 удаа хуваалцсан байна./	4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%

	боловсруулах				Хавсралт: 2 файл		
2	Боловсролын сургалтын байгууллагын хоол үйлдвэрлэл, үйлчилгээг сайжруулах зорилгоор олон улсын байгууллага, төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран ажиллах	Хамтарч ажилласан байгууллагын тоо Гүйцэтгэлийн хувь	0	1	Боловсролын сургалтын байгууллагын хоол үйлдвэрлэл, үйлчилгээг сайжруулах зорилгоор Дэлхийн зөн олон улсын байгууллагатай хамтран цахим контент боловсруулсан. 1. Дэлхийн зөн олон улсын байгууллагатай хамтран Дундговь аймгийн Сайнцагаан сумын Мандал сургуулийн дунд, ахлах ангийн суралцагчдыг үдийн хоолонд эцэг эхийн дэмжлэгээр хамруулж буй "Өсвөр насны хүүхдийн хоол шим тэжээл" контент бэлтгэсэн. Линк: https://www.facebook.com/share/v/16HmrJK1Wo/?mibextid=wWxIf 2. Суралцагчдын хоол үйлдвэрлэл, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах чиглэлээр Боловсролын яам, GPE олон улсын байгууллагатай хамтран "Хүүхдийн хоол" хэлэлцүүлгийг УИХ-ын гишүүд болон холбогдох яам, сургууль, цэцэрлэгийн төлөөлөл, олон улсын байгууллагуудыг хамруулан 75 хүний бүрэлдэхүүнтэйгээр 2025 оны 05 дугаар сарын 20-ний өдөр Чингис хаан үндэсний музейд зохион байгуулсан. 3. Койка олон улсын байгууллагын зохион байгуулсан төрийн албан хаагчдын сургалтад 2025 оны 06 дугаар сарын 05-ны өдөр хамрагдсан. Хавсралт: 4 файл	3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%
3	Ерөнхий боловсролын сургуулийн дунд, ахлах ангийн суралцагчдын хоол, шим тэжээлийн бодит нөхцлийг тодорхойлох чиглэлээр эцэг эх, асран хамгаалагчда	Судалгаанд хамрагдсан хүний тоо	0	15000	Ерөнхий боловсролын сургуулийн дунд, ахлах ангийн суралцагчдын хоол, шим тэжээлийн бодит нөхцлийг тодорхойлох, цаашид сайжруулах үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлох зорилгоор эцэг эх, асран хамгаалагчдаас 12 асуулт бүхий судалгааны асуумж боловсруулсан. Боловсролын ерөнхий газрын даргын 2025 оны 05 сарын 25-ны өдрийн 1/1932 тоот албан бичгээр 21 аймаг, 9 дүүрэгт судалгаа авах асуумжийг хүргүүлсэн. Тус судалгаанд нийт 21800 эцэг эх, асран хамгаалагч хамдагдсан бөгөөд үүний 64.1% нь аймаг, 35.9% нь нийслэлээс оролцсон байна. Судалгааны үр дүнд: 1. Судалгаанд хамрагдсан сурагчдын 36.7% нь өглөөний цай тогтмол ууж хэвшсэн хааяа уудаг 57.4%, огт өглөөний цай уудаггүй сурагч 5.4% байна. 2. Сургууль дээрээ хоол	4-р сар, 5-р сар, 6-р сар	100%

	ас судалгаа боловсруулан авах				хүнсний бүтээгдэхүүнээр хангагдсан байдлыг судлахад 59.8% нь сургуулийн орчинд хүнсний бүтээгдэхүүн худалдан авалт хийдэг, гэрээсээ идэх зүйлээ авч явдаг 16.1%, огт юм иддэггүй 24.1% байна. 3. Эцэг эхчүүд хүүхдийн хоол, шим тэжээлийн байдлыг 48.6% нь сайн гэж үнэлсэн бол 38.7% нь сайжруулах шаардлагатай, 12.2% нь хангалтгүй гэж үзсэн. Хүүхдийн хоол шим тэжээлийн байдлыг хангалтгүй гэж үзсэн эцэг эх, асран хамгаалагчдын хувьд 39.8% нь хүнсний бүтээгдэхүүний үнэ өссөн, 29.3% нь жимс, сүү зэрэг бүтээгдэхүүнийг тогтмол худалдан авахад эдийн засгийн боломж хүрэлцдэггүй, мэдлэг, мэдээлэл хангалтгүй 16.4% байна. Хоол шим тэжээлийн талаар мэдээлэл авч буй эх үүсвэр нь 72,8% нь цахим сүлжээ буюу facebook, instagram гэсэн байв. Судалгааны үр дүнд үндэслэн эцэг эх, асран хамгаалагчдын хоол, шим тэжээлийн мэдлэг, ойлголтыг сайжруулах зорилгоор "Шим тэжээлийн боловсрол" арга зүйн цахим контентийг боловсруулсан. https://we.tl/t-mNmZ5JVAom		
Хавсралт: 3 файл							
1.2. Хяналтын зөвлөлийн үйл ажиллагаа, эцэг эх, асран хамгаалагчийн оролцоог хангах чиглэлээр сургалт, судалгаа хийх, зөвлөмж, аргачлал боловсруулах төлөвлөгөөни хэрэжилтийг зохион байгуулах, зохицуулахад мэргэжил арга зүйн удирдлага мэдээллээр хангах							
4	Тусгай хэрэгцээт сургууль, цэцэрлэгийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд хяналт, шинжилгээ, үнэлгээ хийнэ.	Хамрагдсан байгууллагын тоо Гүйцэтгэлийн хувь	0	1	Боловсролын ерөнхий газрын даргын 2025 оны 05 дугаар сарын 23-ны өдрийн А/135 дугаар тушаалаар Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Нийслэлийн Боловсролын газар, Нийслэлийн Хүнс, хөдөө аж ахуйн газартай хамтран тусгай хэрэгцээт хүүхдийн хоол, шим тэжээлийн бодит нөхцөл байдлыг тодорхойлох зорилгоор 4 сургууль, 2 цэцэрлэгт ажилласан. Үүнд: -Нийслэлийн Сүхбаатар дүүргийн ерөнхий боловсролын 29, 116 дугаар сургууль, 186 дугаар цэцэрлэг, -Баянзүрх дүүргийн ерөнхий боловсролын 55 дугаар сургууль, 10 дугаар цэцэрлэг, -Хан-Уул дүүргийн 63 дугаар сургууль хамрагдсан. Боловсролын байгууллагын хоол үйлдвэрлэл, үйлчилгээ, хоолны илчлэг, шим тэжээлийн байдлын тэнцвэртэй байдлыг судлан үзэхэд 116, 29 дүгээр сургуулийн дотуур байранд хамрагдаж буй сурагчид "Үдийн хоол" хөтөлбөрт давхар хамрагдаж байгаа нь тогтоогдсон бөгөөд өдөрт авах	3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%

					илчлэг шим тэжээлийн хувь бодлогын баримт бичгийн дагуу 130% байна. Нийслэлийн 116 дугаар сургуулийн хоолны илчлэг шим тэжээлийн байдал цэс төлөвлөлт технологийн картнаас зөрүүтэй байгаа нь мэргэжлийн хоол зүйч ажиллуулах шаардлагатайг харуулж байна. Хяналт шинжилгээ, үнэлгээгээр сургууль, цэцэрлэгийн хоолны цэс төлөвлөлт, технологийн карт харилцан адилгүй байсан тул нэгдсэн жишиг цэс, технологийн картны загвар боловсруулахаар төлөвлөж байна. Хавсралт: 14 файл		
5	Суралцагчын хоол үйлдвэрлэл, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах чиглэлээр хэлэлцүүлэг зохион байгуулна.	Зохион байгуулсан хэлэлцүүлгийн тоо Гүйцэтгэлийн хувь	0	1	Суралцагчдын хоол үйлдвэрлэл, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах чиглэлээр Боловсролын яам, ГРЕ олон улсын байгууллагатай хамтран “Хүүхдийн хоол” хэлэлцүүлгийг 2025 оны 05 дугаар сарын 20-ний өдөр Чингис хаан үндэсний музейд зохион байгуулсан. Хэлэлцүүлэгт УИХ-ын гишүүд болон холбогдох яамд, сургууль, цэцэрлэг, олон улсын байгууллагуудын төлөөлөл нийт 75 албан хаагч хамрагдсан. Цэцэрлэг сургууль, дотуур байрын батлагдсан төсөвт багтаан хэрэгжүүлж буй 40 бодит хоол болон шим тэжээлийн хэрэгцээг бүрэн хангасан тэнцвэртэй 40 хоол нийт 80 төрлийн хоолыг бэлтгэн танилцуулсан. Хэлэлцүүлэгт оролцогчид хүүхдийн хоолны чанар хүртээмжийг сайжруулахад төсвийг нэмэгдүүлэх, дунд, ахлах ангийн сурагчдыг "Үдийн хоол" хөтөлбөрт хамруулах, эрүүл ахуйн нөхцөл байдлыг сайжруулахад аяга, таваг угаагчаар бүрэн хангах, хүнсний хангамжийн тогтолцоог бэхжүүлэх, хоол үйлдвэрлэл, үйлчилгээний ажилчдын цалин хөлсийг нэмэгдүүлэх шаардлагатай талаар хэлэлцэж санал нэгдсэн. Хавсралт: 9 файл	3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 11-р сар, 12-р сар	100%
6	Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний	Хамрагдсан байгууллагын тоо Гүйцэтгэлийн хувь	0	10	Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний хэрэгжилтэд үнэлгээ хийх ажлын хүрээнд дараах ажлыг хийж гүйцэтгэсэн. Үүнд: 1. БЕГ-ын даргын 2025 оны 03 дугаар сарын 20-ний А/73 дугаар тушаалын дагуу ТХААГ, НЗДТГ, НБГ, НХААГ, НЭМГ -тай хамтран нийслэлийн ерөнхий боловсролын 7 сургууль (14, 158, 52,	4-р сар, 5-р сар, 6-р сар, 9-р сар, 10-р сар, 11-	100%

	хэрэгжилтэд үнэлгээ хийнэ.				31, 124, 28, 145 дугаар сургуулиуд), 4 цэцэрлэгийн (302, 71, 160, 38 дугаар сургуулиуд) хоол үйлдвэрлэл, үйлчилгээ, хүнсний хангамж, худалдан авалт, ерөнхий гэрээний нийлүүлэгч 15 аж ахуй нэгжүүдийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн. 2. Боловсролын ерөнхий газрын даргын 2025 оны 05 дугаар сарын 23-ний А/135 дугаар тушаалын дагуу Нийслэлийн Засаг даргын Тамгийн газар, Нийслэлийн Боловсролын газар, Нийслэлийн Хүнс, хөдөө аж ахуйн газартай хамтран нийслэлийн зарим цэцэрлэгийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээ болон хоол үйлдвэрлэл, үйлчилгээг түрээсийн гэрээгээр хэрэгжүүлдэг ерөнхий боловсролын сургуулийн түрээсийн гэрээг үе шаттай дуусгавар болгох чиглэлээр ерөнхий боловсролын 12 сургуульд (133, 102, 33, 44, БЗЦ, 97, 84, 12, 104, 105, Хөгжил, 162) хяналт, шинжилгээ-үнэлгээ хийж илэрсэн зөрчлийг арилгах тусгай хэрэгцээт хүүхдийн хоол, шим тэжээлийг сайжруулах чиглэлээр Нийслэлийн ерөнхий боловсролын 29, 116, 55, 63 дугаар сургууль, 186, 10 дугаар цэцэрлэгийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээ, хоолны илчлэг, шим тэжээлийн байдлыг үнэлж, зөвлөн тусалж ажилласан. 3. Боловсролын ерөнхий газрын даргын 2025 оны 04 дугаар сарын 01-ний А/84 дүгээр тушаалын дагуу Нийслэлийн Чингэлтэй дүүргийн ерөнхий боловсролын 4 сургууль (17, 5, 23, 24 дүгээр сургуулиуд) болон сургуулийн өмнөх боловсролын 3 байгууллагад (56, 83, 246 дугаар цэцэрлэг) Боловсролын ерөнхий хуулийн 33 дугаар зүйлийн 33.3 дахь хэсэгт заасан чиг үүргийн хэрэгжилт, сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн 17 дугаар зүйлийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ үнэлгээ хийж мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан Хавсралт: 12 файл	р сар, 12-р сар	
3.1. Нэгжийн үйл ажиллагаанд оролцож, дэмжлэг үзүүлэх, удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг биелүүлэх, хууль тогтоомжоор хүлээсэн бусад чиг үүргийг хэрэгжүүлэх							
7	Цаг үеийн болон бусад асуудлаар удирдлагыг	Үүрэг даалгавар биелэлтийн	0	100% биелүүлж ажиллана.	1. 2025 оны 03 сарын 25-ны өдөр "Хүүхдийн хоол үйлдвэрлэл, шим тэжээлийн сургалт арга зүйн үндэсний төв"-ийн зохион байгуулсан "Хоол зүйч мэргэжил сурталчлах өдөрлөг"-т оролцсон.	3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар,	100%

	үнэн зөв бодит мэдээллээр хангах, өгсөн үүрэг, даалгаврыг биелүүлэх нэгжийн өдөр тутмын дотоод үйл ажиллагаанд оролцох, зохион байгуулах	хувь			https://www.facebook.com/share/p/1Bnvo8Ezwy/?mibextid=oFDknk 2. Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 339, 340 дүгээр тогтоол, 2017 оны 67 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах хүрээнд МУБИС-ийн харьяа ерөнхий боловсролын сургуульд хувиарлагдаж 2025 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн 16:00 цагт гамшгийн аюулын зарлан мэдээллийн дохиогоор газар хөдлөлтийн аюулаас урьдчилан сэргийлж ажилласан. 3. Хүүхдийг Ивээх Сангийн Монгол Улс дахь Суурин төлөөлөгч Л.Баян-Алтай болон төслийн багийнхантай хамтарсан уулзалтад оролцсон. https://www.facebook.com/share/p/1BZoninDCD/ Хавсралт: 4 файл	7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	
8	Төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулах, тайлагнах, дүгнүүлэх ажлыг хугацаанд нь чанартай гүйцэтгэх	Тухай бүрд нь гаргаж ажиллах	0	100%-ийн гүйцэтгэлтэй ажиллана.	Төрийн албан хаагчийн 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг хугацаанд боловсруулж, системд оруулсан. Хавсралт: 1 файл	3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%
9	Боловсролын ерөнхий газрын удирдлага, бусад нэгжээс шаардсан ажлын чиг үүрэгтэй холбоотой мэдээлэл судалгааг	Тухай бүрд нь гаргаж ажиллах	0	100%-ийн гүйцэтгэлтэй ажиллана.	1. Боловсролын яам, Боловсролын ерөнхий газар, GPE олон улсын байгууллагын хамтран зохион байгуулсан "Хүүхдийн хоол" хэлэлцүүлэгт танилцуулах гарын авлагын ус цэвэршүүлэгчийн судалгааг 21 аймаг, 9 дүүргээс авч нэгтгэсэн. 2. Улсын хэмжээнд төрийн өмчийн ерөнхий боловсролын сургуулийн дунд, ахлах ангийн суралцагчид болон бага ангийн суралцагчдын тоог аймаг, нийслэлээр нь нэгтгэж, бүсэд хуваасан. 3. Дунд, ахлах ангийг "Үдийн хоол" хөтөлбөрт хамруулахад шаардагдах төсвийг нийт суралцагч, хүний нөөц, тоног төхөөрөмж бүрээр нь тооцсон судалгааны ерөнхий тоог гаргаж Боловсролын яаманд	3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%

	шуурхай чанартай гаргаж өгөх				хүргүүлсэн. 4. 21 аймаг, 9 дүүргээс дотуур байртай сургуулийн тоо, сургууль, дотуур байрын гал тогоо, тоног төхөөрөмжийн судалгааг нэгтгэж мэдээлийг Боловсролын яаманд хүргүүлж гарын авлагат мэдээлэл орсон. Хавсралт: 2 файл	сар	
1 0	Албан хэрэг хөтлөлтийн стандартыг хэрэгжүүлж эрхлэх асуудлын чиг үүрэгт хамаарах мэдээ, мэдээлэл тайлан холбогдох материалыг “Боловсролын ерөнхий газрын хөтлөх хэргийн жагсаалт”-ын дагуу архивын нэгж болгон хадгалуулах	Архивын нэгжийн тоо	0	Хөтлөх хэргийн жагсаалтын дагуу архивын нэгж болгон хадгалуулна.	Албан хэрэг хөтлөлтийн стандартыг хэрэгжүүлж эрхлэх асуудлын чиг үүрэгт хамаарах мэдээ, мэдээлэл тайлан холбогдох материалыг “Боловсролын ерөнхий газрын хөтлөх хэргийн жагсаалт”-ын дагуу архивын нэгж болгон хадгалуулсан.	3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%

НЭМЭЛТ АЖЛЫН БИЕЛЭЛТ

№	Үүрэг даалгавар	Өгсөн субъект	Биелэлт
1	2	3	4

ХОЁР. МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт	Эхэлсэн, дууссан хугаца	Биелэлтийн хувь
1	2	3	4	5		6	7
4.1. Төрийн албаны тухай хууль, салбарын хууль, дагалдан гарсан хууль тогтоомжид заасан мэдлэг чадварыг эзэмших, тасралтгүй хөгжүүлэх							
1	Байгууллага дотоодоос зохион байгуулсан сургалтад хамрагдах	тухай бүрд хамрагдах	0	өөрийгөө хөгжүүлэх	1. Койка олон улсын байгууллагын зохион байгуулсан төрийн албан хаагчдын сургалтад 2025 оны 06 дугаар сарын 05-ны өдөр хамрагдсан. 2. 2025 оны 06 дугаар сарын 02-04-ний өдрүүдэд Боловсролын яам, Боловсролын ерөнхий газар, Койка олон улсын байгууллага, WITH олон улсын байгууллага хамтран зохион байгуулсан хоол зүйч нарт зориулсан "Сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний удирдамжийн MASTER TRAINER сургалтад хамрагдсан. 3. 2025 оны 05 дугаар сарын 08 -ны өдөр БЕГ-ын 202 тоотод Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн танилцуулга сургалтад хамрагдсан 4. 2025 оны 03 сарын 25-ны өдөр "Хүүхдийн хоол үйлдвэрлэл, шим тэжээлийн сургалт арга зүйн үндэсний төв"-ийн зохион байгуулсан "Хоол зүйч мэргэжил сурталчлах өдөрлөг"-т оролцсон. https://www.facebook.com/share/p/1Bnvo8Ezwy/?mibextid=oFDknk Хавсралт: 7 файл	3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%

ТАЙЛАН ГАРГАСАН:

Хоол үйлдвэрлэл үйлчилгээний эцэг, эхийн оролцоо, хяналт хариуцсан мэргэжилтэн, Дамдиндорж Номин-Эрдэнэ
/...../ Огноо: